

БАТЛАВ.
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА Ц.ТӨРБИЛЭГ

Огноо. 2024.04.08

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ ХООЛ
ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Гэрээний дугаар: ДУАОБГ/20240202001

Онцгой байдлын газар 2024 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Онцгой байдлын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос аймгийн Онцгой байдлын газарт хоол хүнсний материал нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 10:00 цаг хүртэл хүлээн авна.

Үнийн саналыг 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

***Дундговь аймгийн Онцгой байдлын газар
Харилцах утас: 70593850,***

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, / болон бусад баримт бичиг;
(д) Харьяа татварын хэлтэст өргүй талаарх тодорхойлолт |
| 4. Тохируулгын нөхцөлтэй үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд суурь үнэ өөрчлөгдсөн нөхцөлд тохируулгын үнээр бараа материал нийлүүлнэ. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 жилийн буюу 2023 оны санхүүгийн тайлан. 2. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлого нь 10 сая төгрөгөөс багагүй байх 3. Харьяа татварын хэлтэст өргүй талаарх тодорхойлолт 2024 оны 3 сарын байдлаар /QR кодтой/ 4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 5. Бараа бүтээгдэхүүний тохиролын гэрчилгээ
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дундговь аймаг, Буяаннэмэхийн гудамж Онцгой байдлын газар 307 тоот өрөө</p> <p>Огноо: 2024-04-30 Цаг: 10:00 цаг</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дундговь аймаг, Онцгой байдлын газар 307 тоот өрөө</p> <p>Огноо: 2024-04-30 Цаг: 10:30 цаг</p>
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 2

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** 30 нэр төрөл бүхий хоол хүнсний материал
2. **Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.
3. **Баглаа, боодол:** Зориулалтын
4. **Бараа хүргэх газар:** Дундговь аймгийн Онцгой байдлын газар
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Барааг нийлүүлэх эцсийн хугацаа 2024 оны 12 сарын 31

Багц 1.Мах махан бүтээгдэхүүн

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Хонины мах	MNS 67.120.10	746	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Ямааны мах	MNS 67.120.10	300	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	

Багц 2.Бусад

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1-р гурил	MNS 244:2009	255	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Цагаан будаа	MNS (ISO) 7301:2000	306	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Ургамлын тос	Гост Р 52465:2005	36	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Төмс	MNS 258:2006	125,5	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Лууван	MNS 0270:1982	102	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Манжин	MNS 255:2007	51	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Байцаа	MNS 255:2007	256	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Сонгино	MNS 255:2007	102	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Давс	MNS 5046:2001	108	Кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Цуу	MNS 5512:2005	36	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Кетпуп	MNS 5519:2005	18	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Перец	MNS 5519:2005	36	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Дашидо	MNS 5519:2005	18	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Хоол амтлагч	MNS 5519:2005	18	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Зайдас	MNS 5519:2005	1250	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Өндөг	MNS 5519:2005	1250	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Талх	MNS 5519:2005	365	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Сүү	MNS 5519:2005	510	л	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	

Сахар	MNS 5519:2005	175	кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Масло	MNS 5519:2005	132	кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Варень	MNS 5519:2005	102	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Пүнтүүз	MNS 5519:2005	35	ш	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	
Үзэм	MNS 5519:2005		кг	ОБГ	2024 оны 01 сарын 01	2024 оны 12 сарын 31	

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Сарын хэрэглээ	Сарын мөнгөн дүн	Жилийн хэрэглээ	Жилийн мөнгөн дүн	Хэрэгцээ шаардлага
1	Хонины мах	кг	11,000	133	1,463,000	746	8,206,000	Шинэ амт чанар сайтай, шинжилгээний бичигтэй байх
2	Ямааны мах	кг	10,000	50	500,000	300	3,000,000	
3	Гурил	кг	3,000	44	132,000	255	765,000	
4	Будаа	кг	2,850	26	74,100	306	872,100	Улаанбаатарын 1-р гурилтай дүйцэхүйц
5	төмс	кг	2,100	217	455,700	125,5	263,710	БНХАУ-ын улаан сүмтэй будаатай дүйцэхүйц
6	Байцаа	кг	2,000	44	88,000	256	512,000	Монгол үрийн ногоотой дүйцэхүйц байх
7	Сонгино	кг	2,400	20	48,000	102	244,800	
8	Манжин	кг	2,400	9	21,600	108	122,400	
9	Лууван	кг	2,300	18	41,400	102	234,600	
11	Давс	ш	1,300	10	13,000	108	140,400	
12	Дашидо	ш	8,400	3	25,200	18	151,200	1 кг-ын савлагаатай МОН давстай дүйцэхүйц байх
13	Амтлагч	ш	4,000	3	12,000	18	72,000	Хоол амт оруулах чанар сайтай дашидо амтлагчтай дүйцэхүйц байх
14	кетчуп	ш	4,000	8	32,000	18	72,000	Хоол амт оруулах чанар сайтай дашидо амтлагчтай дүйцэхүйц байх
15	Цуу	ш	3,500	8	28,000	36	126,000	500 гр савлагаатай чили кетчуптай дүйцэхүйц байх
16	Ургамлын тос	ш	6,500	11	71,500	36	234,000	БНХАУ-ын чин суцуутай дүйцэхүйц байх
17	Перец	ш	4,500	3	13,500	36	162,000	Өтгөн тослог ихтэй supply gold тостой дүйцэхүйц байх
18	Зайдас	ш	800	240	192	1250	1,000,000	Хоол амт оруулах чанар сайтай нунтаг хар перец байх
19	Өндөг	ш	550	240	132,000	1250	687,500	Шинэ амт чанар сайтай, шинжилгээний бичигтэй байх
20	Талх	ш	1,850	130	240,500	365	675,250	Шинэ амт чанар сайтай, шинжилгээний бичигтэй байх
21	Сүү	ш	5,000	86	430,000	510	2,550,000	Мишээл талхтай дүйцэхүйц чанартай байх

22	Сахар	кг	2,600	30	78,000	175	455,000	Монгол улсад үйлвэрлэсэн байх
23	Шар будаа	кг	3,000	16.5	49,500	198	594,000	Орос улсын сахартай дүйцэхүйц байх
24	Хөц будаа	кг	3,000	16.5	49,500	204	612,000	Алайка үйлдвэрийн будаатай дүйцэхүйц байх
25	Масло	кг	6,520	13	84,760	132	860,640	Монгол улсад үйлвэрлэсэн байх
26	Варень	ш	5,000	11	55,000	102	510,000	Чанарын шаардлага хангасан байх
27	Пүнтүүз	ш	4000	17	68,000	35	140,000	Чанарын шаардлага хангасан байх
Дүн			xxx	xxx	4348760	xxx	22668600	

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 6 сараас багагүй байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгаж, туршиж хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: Нэг 7 хоногт 0.5

Алдангийн нийт дүн: |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]